

## С.ГАЛИНДЭВИЙН НАМТАР, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДРУУЛАХУЙ

Н.БАТБОЛД

**Товч агуулга:** С.Галиндэв нь Дөрвөд далай хан аймгийн Дайчин вангийн хошууны сүүлчийн засаг ноён Н.Самданжамцын удмын тайж Сайрын хүү юм. Түүнийг уул нутгаас нь Дотоодыг Хамгаалах газрын дарга З.Шижээ татан авчирж, тус газар төлөөлөгчөөр ажиллуулсан байна. Тэрээр Дотоодыг Хамгаалах Газар, Дотоод Явдлын Яаманд ажиллахдаа 1932 оны эсэргүү хөлөлгөөнийг дарах, 1937 оны их хэлмэгдүүлэлтийг ЗХУ-аас ирсэн сургагч нарын заавраар явуулахад ДЯЯ-ны Нууц улс төрийн хэлтсийг толгойлон оролцсон хүн юм. Улмаар Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар томилогдож, Ерөнхий сайд А.Амарыг төрийн удирдлагаас унагах төлөвлөгөөт ажилд татагдан оролцож, түүний эсрэг шүүмжлэл илтгэлийг 22 дугаар Бага хурал дээр тавьж байжээ. Төдөлгүй С.Галиндэвийг “тайж” гаралтай, урваж мэдэх хүн хэмээнээр 1939 онд улс төрийн хилс хэрэгт баривчилж, ЗХУ-д алын дээд хэмжээгээр шийтгэжээ.

**Түлхүүр үг:** Сайрын Галиндэв, уг гарал, Дотоодыг Хамгаалах Газар, Дотоод Явдлын Яам, Эрүүлийг Хамгаалах Яам, хэлмэгдүүлэлт

Ардын Засгийн газраас 1922 онд “Ван гүнгийн эрх хэмжээний дүрэм”, “Хамжлага ардуудыг сум эрийн тоонд оруулах тухай” зэрэг дүрмүүдийг баглан гаргаж, улмаар “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм” гарснаар Монгол Улсын нутагт оршиж байсан угсаа залгамжилан захирах тогтолцоог өөрчилсөн билээ. Ингэснээр удам дамжин угсаа залгамжилж ирсэн алтан ургийн засаг ноёдын хувь заяаны асуудал сөхөгдөн гарч иржээ. Шинэ тутам байгуулагдсан Засгийн газраас сүүлчийн засаг ноёд, тэдний ураг төрлийнхний хувь заяаны асуудал дээр ямар бодлого баримталсан, сүүлчийн засаг ноёд, тэдгээрийн удам, хойч үеийнхэнд тэрхүү бодлого ямар байдлаар нөлөөлсөн, түүнийг хэрхэн даван туулсанг судлан гаргаж ирэх нь судалгааны чухалтай юм.

Сүүлчийн засаг ноёдын ураг төрлийнхний хувь заяаны асуудал сэдвийн хүрээнд энэ удаа МАХН, төр, гүйцэтгэн захирамжлах дээд байгууллагын тогтоол, тушаал<sup>1</sup>-аар хэлмэгдүүлэлтийг явуулж байсан Дотоодыг Хамгаалах Газар, Дотоод Явдлын Яаманд ажиллаж, улмаар хэлмэгдсэн Дөрвөд далай хан аймгийн Дайчин вангийн хошууны сүүлчийн засаг ноён Насанбуянгийн Самданжамцын удамын тайж Сайрын хүү Галиндэвийн хувь заяаны асуудлыг тодруулахыг зорьлоо.

*Нэг. С.Галиндэвийн уг гарвал, бага нас:*



*Сойрын Галиндэв*

С.Галиндэв “Явж ирсэн түүхт байдал”<sup>2</sup> хэмээх бичигтээ: “Дөрвөдийн зүүн гарын чуулган Төгс хүлэг далай хан аймгийн Баатар засгийн хошуу /одоогийн Увс аймгийн Хяргас сум/-ны нутаг Хөх толгой гэдэг газар 1907 онд төрсөн хэмээн тэмдэглэжээ. Галиндэвийн эцэг нь Баатар засгийн хошууны хохь тайж Сойр хэмээх хүн байжээ. Тэрээр Дөрвөд далай хан аймгийн Дайчин вангийн хошууны сүүлчийн засаг ноён Насанбуянгийн Самданжамц<sup>3</sup>-ын ураг төрлийн хүн байв.

Засаг ноён Н.Самданжамц 1919 онд бөмбөг, буу дарагдуулсан хэрэгт 1 жил 6 сар хоригдох ялаар, 1930 оны Төгсбуянтын хүрээний бослого, 1932 оны лам нарын бослого хөдөлгөөнд оролцсон хэмээн 10 жилийн хорих ялаар шийтгүүлэн хоригдож байгаад суллагдсанч, 1937 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Увс аймаг дахь ангийн даргын баталсан 182 дугаар дайчлан баривчлах зөвшөөрлөөр дахин баривчдагдаж, 1938 оны 1 дүгээр сарын 1-нд нэг удаагийн мэдүүлэг өгснөөр П.Гэндэн, Г.Дэмидийн эсэргүү хэрэгт холбогдсон хэмээн 1938 оны 3 дугаар сарын 4-ний Онц Бүрэн эрхт комиссын 8 дугаар хурлаар дээд хэмжээгээр шийтгэсэн

<sup>1</sup> “Дотоодыг Хамгаалах газар бол үнэхээрийн жинхэнэ ядуу ангийн дарангуйлан захирах засагт улсад гадаад, дотоодын хувьсгалын эсэргүү харгим этгээдээс засаг төр, хувьсгалын төв газруудын явуулан байгаа зорилго суртал, хэрэгт хортой явдал гаргахыг завдах буюу харшлан тотгорлох зэргээр саад үзүүлэх этгээдийг тэмцэн устгах үүрэг бүхий газар мөн” Улсын 5 дугаар их хурал. *БНМАУ-ын их бага хурлын тогтоол, үндсэн хууль, тунхагууд*. Улаанбаатар: 1956, 90

<sup>2</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-4, хх-1137

<sup>3</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-5, ц-3340

байна. Засаг ноён Н.Самданжамцын талаар дэлгэрэнгүй судалгааг тусд нь гаргах тул энд цухас дурдаад орхив.

С.Галиндэв 1922 оны өвөл цаг аймгийн чуулган даргын дэргэдэх сургуульд 1924 он хүртэл сууж монгол бичиг заалгажээ. Тэрээр сууж байх хугацаанд “чуулган дарга Н.Самданжамцын охидын ятга хөгжим эвдсэн зэрэг элдэв хэрэг тарьж, чуулган даргын тушаалаар шийтгэгдэж” байжээ. Түүнийг чуулганы бага сургуульд сурсан тухай Дотоодыг Хамгаалах Газарт ирсэн нэгэн илтгэлд: “Төлөөлөгч нөхөр Галиндэв болвоос уулаас Дөрвөдийн аймгийн ван Самданжамцын ойр төрлийн бөгөөд Сэрээ /Сойр/ туслагчийн төрсөн хөвгүүн, тайж язгууртай этгээд болно. Өөрийн төрлийн ван Самданжамцаар уламжлуулж, танил талаар чуулган даргын дэргэдэх сургуульд сурсан”<sup>1</sup> хэмээжээ.

Улмаар С.Галиндэв 1924 онд чуулганы дэргэдэх сургуулийг дүүргээд Баянмандал Уулын хошууны тамганаа бүтэн, тал бичээчээр ажиллах болжээ. 1925 онд тэрээр Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл /МХЗЭ/-ийн гишүүнд элсэжээ. С.Галиндэв 1925 оны 9 дүгээр сард Сангийн яамны дэргэдэх Гаалын анхдугаар түр сургуульд мөн оны 12 дугаар сар хүртэл суралцаж, сургалтын хугацааг дуусгалгүйгээр төгсөлтийн шалгалтыг өгч Сангийн яамны тэргүүн зэрэг боловсорсон үнэмлэх, мөнгөн янтайгаар шагнуулж байжээ.

Улмаар 1926 оны 1 дүгээр сараас эхлэн Тэсийн хүрээний гаалийн хороонд түшмэлээр томлигдон ажиллаж байгаад ар гэрийн газар хүндрэлтэй шалтгаан тохиолдсон тул уул албанаас чөлөө мэдүүлэн Баянмандал уулын хошуунаа иржээ.

1927 онд хуралдсан Чандмань уулын аймгийн их хурлаас С.Галиндэвийг шалган байцаах комиссын гишүүнээр, мөн онд хуралдсан Чандмань уулын аймгийн МХЗЭ-ийн их хурлаас аймгийн эвлэлийн хорооны тэргүүлэгчээр сонгогдож, 1927 оны аравдугаар сарын 6-13-нд хуралдсан МХЗЭ-ийн 6 дугаар их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцожээ. Тус их хурлаас С.Галиндэвийг бүгд хурлын гишүүнээр сонгожээ.

“1928 оны аравдугаар сарын 23-наас арванхоёрдугаар сарын 10 хүртэл хуралдсан МАХН-ын 7 дугаар их хурлаар Коминтерний удирдлага, шууд оролцоотойгоор зүүнтнүүд намын удирдлагад орж нам, улсын албан байгууллагад ажиллаж байсан албан хаагчдыг баруунтан хэмээн шахан зайлуулж шинэ хүмүүсээр албан байгууллагын ажиллах хүчнийг бүрдүүлж эхэлсэн”<sup>2</sup> билээ.

<sup>1</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-5, ц-3340

<sup>2</sup> Дүйнхэржав, Г. *С.Галиндэв*. Улс төрийн хэлмэгдэгсэдийн намтрын товчоон. Улаанбаатар: 2011

Үүнд Н.Хаянхярваагийн толгойлон ажиллаж байсан Дотоодыг Хамгаалах Газар /ДХГ/-ын ихэнх албан хаагчдыг баруунтны гар хөл хэмээн халж нам, эвлэлийн гишүүдээр шинэчлэн бүрдүүлж эхэлжээ. Энэ үед ДХГ-ын даргад зүүнтний нэгэн удирдагч З.Шижээ томилогдон ажиллажээ. Тэрээр 1929 онд ДХГ-ын ажилтнуудыг ихэнхийг өөрчлөхдөө Чандмань уулын аймгийн Баянчандмань уулын хошууны эвлэлийн товчлох хорооны дарга С.Галиндэвийг ДХГ-т татан авч 1929 оны нэгдүгээр сарын 31-нд ДХГ-ын даргын 13 дугаар тушаалаар ДХГ-ын нууц хэлтэст төлөөлөгчөөр шууд томилжээ.

С.Галиндэвийг 1930 онд явагдсан намын гишүүдийн шалгалтанд тайж боловч ажилд сайн, үнэнч шударга гэсэн үндэслэлээр МАХН-ын гишүүн хэвээр үлдээсэн байна.

***Хоёр. С.Галиндэв Дотоодыг Хамгаалах Газар, Дотоод Явдлын Яаманд ажилласан нь:***

С.Галиндэв 1929 оны 1 дүгээр сарын 31-нээс ДХГ-ын Нууц хэлтэст төлөөлөгчөөр томилогдох үед феодалын хөрөнгө хураалт, шашин төрийг тусгаарласан нам төрийн бодлогыг эсэргүүцэн Зөвлөлт Монголын харьцааг таслах зорилгоор байгуулагдсан гэх Ю.Эрэгдэндагвын толгойлсон хэргийг ДХГ илрүүлээд байжээ. Энэхүү хэргийн этгээдүүдийг 1930 оны тавдугаар сарын 1-нээс наймдугаар сарын 30-ны хооронд дайчлан баривчилж мөрдөн байцаалт явуулан хятадын эрх баригчдаас цэргийн тусламж авч ардын засгийн газрыг устгах гэсэн хэргийг хүлээлгэжээ. Энэхүү хэргийг мөрдөн байцаахад сургагч Балдановын удирдлаганд С.Галиндэв оролцон ажиллажээ. С.Галиндэвийн оролцсон энэхүү хэргийг 1990 онд улс төрийн хилс хэрэг хэмээн цагаатгажээ.

1930 оны зургаадугаар сарын 23-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 27 дугаар хурал дээр Коминтерний төлөөлөгч Кучумовоос: “Хар феодалын хөрөнгийг устгахад ангийн тэмцэлээс айх хэрэггүй урагш давшин туйлд хүргэх хэрэгтэй” хэмээн ДХГ-ын ажилтнуудыг шахснаар үүнийг биелүүлэхийн төлөө ажилтнууд ажиллахдаа алдаа завхрал гаргаж эхэлжээ.

1931 оны нутгийн захиргааны шинэчлэлээр шинэ аймгууд байгуулагдахад ДХГ-аас бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж 1931 оны аравдугаар сарын 9-нд 257 дугаар тушаал гарган Архангай аймагт салбар хэлтэс байгуулан даргаар нь С.Галиндэвийг томилжээ. Тэрээр шинэ тутам байгуулагдсан хэлтсийг албан ажил явуулах байр, ажилтнуудын орон сууц, бичиг хэрэгсэл, уналагаас

эхлүүлээд томоохон асуудлуудыг бүрэн шийдвэрлэж чаджээ. Улмаар түүнийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс Улсын арван жилийн ойг тохиолдуулан Цэргийн гавьяаны 1 дүгээр зэргийн одонгоор шагнажээ.

1932 оны дөрөвдүгээр сарын 10-нд Рашаантын хүрээнээс эхэлсэн эсэргүү бослого даамжран Архангай аймгийн нутаг дэвсгэрийг хамарч Засгийн газар энэ талаар хуралдан бослогыг дарах комиссыг томилжээ. Энэ ДХГ-ын Архангай хэлтсийн дарга С.Галиндэвт Рашаантын хүрээнд гарсан бослогыг дарахад тусал гэсэн үүргийг ДХГ-ын удирдлагаас өгсний дагуу Архангай аймгаас Намын хянан байцаах комиссын дарга Базарсад, С.Галиндэв нар хорь орчим хүнийг цуглуулж, Хөвсгөл аймгаас ирсэн Ж.Баясгалан даргатай отрядтай хүч хавсран бослогыг дарах ажилд оролцож эхэлжээ.

Мөн Засгийн Газрын бүрэн эрхт комиссын дарга Г.Содном Архангай аймгийн цэргийн хорооны түр цэргээс 30-40 хүнтэй нэг салаа, аймгийн албан хаагчдаас мөн тооны хүн авч 70-80 хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын отряд байгуулахад отрядын бүрэлдэхүүнд ДХГ-ын ажилтан Н.Цэдыпов, С.Галиндэв нар оржээ. С.Галиндэв 1932 оны 5 дугаар сарын 22-нд Дотоодыг Хамгаалах Газарт: “Содномын отряд 5 дугаар сарын 13-нд байлдаж эсэргүү нараас 100-аад хүн алагдаж, 100-аад хүн шархдсан. Эсэргүү нар 18-нд Архангай төвийг эзлэхээр Тариатаас гарсан боловч 19-ний өдөр Гичгэний голд Өлзийбатын отрядтай тулгарч буудалцаад олон хүнээ алуулж, зарим нь зугтжээ”<sup>1</sup> хэмээн бослогын нөхцөл байдлыг цаг тухайд нь мэдээллэж байжээ. Энэ отряд Тэрхийн голоор Тариатын хүрээний зүг давшилтанд орж 1500 гаруй босогчдын эсрэг байлджээ. Тариатын хүрээний тулгаралтанд отрядын дарга Г.Содном, ДХГ-ын ерөнхий сургагч В.С.Киековский, ДХГ-ын төлөөлөгч Л.Аюушжав нар амь эрсдсэн байна. Тулгаралтын дараа 1932 оны тавдугаар сарын 9-нд Монгол Ард Улсыг Батлан Хамгаалах Зөвлөл “Хөвсгөл, Архангай аймгууд дахь Улс төрийн байдлын тухай” авч хэлэлцээд эсэргүү хөдөлгөөнийг дарах явдлыг шууд удирдаж ажиллахын тулд Хөвсгөл ба Архангай аймгуудын нутагт Батлан хамгаалах түр зөвлөл байгуулан зөвлөлийн даргад Монгол ардын хувьсгалт улаан цэргийн зөвлөлийн гишүүн ба МАХУЦ-ын Улс төрийн газрын дарга Д.Өлзийбат, гишүүдэд Архангай аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга нөхөр Г.Гончигдорж, аймгийн захиргааны дарга Б.Дамбаринчин, 10 дугаар дивизийн дарга Гомбосүрэн, мөн дивизийн комиссар Д.Гомбожав, цэргийн хамтарсан сургуулийн сургагч нөхөр Юшкеевич, Архангай аймгийн Дотоодыг Хамгаалах хэлтсийн дарга С.Галиндэв нарыг томилжээ.

<sup>1</sup> Лувсан-Очир, Ч. *Аравхан насандаа аюулыг сөрсөн нь*. Улаанбаатар: 2003, 16

С.Галиндэв бослого хөдөлгөөн гаргагчдын дунд тагнуулын ажлыг шуурхай зохион байгуулж, мэдээллүүдийг авснаар эсэргүү хөдөлгөөнийг амжилттай дарж чаджээ. Эсэргүү хөдөлгөөний үеэр удирдан ажиллаж байсан хэлтсийн ажилтнууд хариуцлага алдсан тул ажилтуудын хамт хариуцлага хүлээсэн байна. Тухайлбал: 1932 оны 8 дугаар сарын 15-нд Дотоодыг Хамгаалах Газрын дарга 240 дугаар тушаалаар: “1932 оны Тариатын хүрээний бослогоор Тариатын хүрээний тулгаралтанд Архангай хэлтсийн ажилтан Цэдэв нь пулемёт буу эвдэж, машин авч ухарсан нь машин явах замгүй болж жолооч нар нь баригдсан. Хайхрамжгүй хандсанаа илэрхийлж уучлалт гуйсан тул Цэдэв, Ангийн дарга Галиндэв нарыг хатуугаар донгодож, сануулах<sup>1</sup>” арга хэмжээ авчээ.

С.Галиндэвийг 1932 оны дөрөвдүгээр сарын 8-нд ДХГ-ын даргын 144 дүгээр тушаалаар Архангай аймгийн Дотоодыг хамгаалах хэлтсийн даргаас өөрчилсөн боловч бослогыг дарагдтал хувьсгалт цэргийн түр зөвлөлийн гишүүнээр ажиллуулж байгаад 1932 оны долдугаар сарын 21-нд ДХГ-ын даргын 233 дугаар тушаалаар ДХГ-ын Нууц улс төрийн хэлтэст тасгийн даргаар томилон ажиллуулжээ. С.Галиндэвийг ДХГ-ын 10 жилийн ойг тохиолдуулан лам нарын эсэргүү хөдөлгөөнийг дарах ажилд оролцож, ардын сайн дурын партизан цэргийг тэргүүлэн 2 сар гаран явж сайтар ажилласан тул бие хамгаалах буугаар шагнажээ.

С.Галиндэвийн ДХГ-г хэрхэн ажилласан талаар 1934 оны 3 дугаар сарын 6-нд Нууц бөгөөд Улс төрийн хэлтсийн дарга Шаравжамц: “Нөхөр Галиндэвийн тус газар ажилласан бүтэмжийн зүйлүүд бэлхэн тодорхой байх тул түүний одоогийн өдөр тутмын ажлын удирдлага ба хүний зан байдлын тухайд тэмдэглэх нь нөхөр Галиндэв өдөр тутмын өөрийн ажил дээр дадлага туршлагыг олсон ба идэвхитэйгээр ажилладаг, зан байдлын талаар шудрага, томоотой болно<sup>2</sup>” хэмээн тодорхойлж байжээ.

Улмаар 1936 оны гуравдугаар сарын 3-нд ДЯЯ-ны сайдын 2 дугаар тушаалаар С.Галиндэвийг Нууц улс төрийн хэлтсийн даргаар дэвшүүлэн томилж, 1936 оны 7 дугаар сарын 19-ний ДЯЯ-ны сайдын 85 дугаар тушаалаар Чекистийн хүндэт тэмдгээр шагнасан байна.

1936 оны гуравдугаар сарын 22-нд Улсын 20 дугаар бага хурлаас гаргасан тогтоолд Дотоодыг Хамгаалах Газар нь 15 жилийн дотор эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн хувьсгалын замаар “гадаад дотоодын дайсан этгээдүүдийн

<sup>1</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-4, хх-1137

<sup>2</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-4, хх-1137

өмнөөс эсэргүүцэн тэмцэх явдалд чухал нэгэн зэвсэг”<sup>1</sup> болж үүрэг зорилго нь улам хүнд болсноос түүнийг Дотоод Явдлын Яам /ДЯЯ/ болгон өргөтгөжээ.

1937 оны наймдугаар сарын 24-нд ЗХУ-ын ДХАК-ын орлогч дарга М.П.Фриновский, Батлан Хамгаалах Яамны орлогч сайд, Улс төрийн газрын дарга В.В.Смирнов, БНМАУ-д шинээр суух элчин сайд С.Н.Миронов нар урилгагүйгээр гэнэт хүрэлцэн ирж ДЯЯ-ны сайд Х.Чойбалсанд үүрэг өгч ДЯЯ-ны Улсыг аюулаас хамгаалах байгууллагын ажилтны орон тоог нэмэгдүүлж ЗХУ-д болон ДЯЯ-ны Төв сургуулийн гүйцэтгэх курст сууж байсан 41 сурагчдыг сургуулийг нь төгсгөж шууд төлөөлөгчөөр томилсон байна. Улмаар ЗХУ-ын ДХАК-ыг орлогч М.П.Фриновский 1937 оны наймдугаар сарын 28-наар өдөрлөсөн “Заговор №1” /Хавсралт-1/ нэртэй даруй баривчлах 115 хүний нэрсийн жагсаалт, П.Гэндэгийн мэдүүлгийг ДЯЯ-ны сайд Х.Чойбалсанд өгчээ. Ийнхүү ЗХУ-аас ирсэн элчин, дарга нарын даалгавраар дайчлан баривчлах хүмүүсийн нэрс, бэлтгэл ажлыг гүйцэтгэсний дараа 1937 оны есдүгээр сарын 10-нд ДЯЯ-ны ажилтнуудыг тус яамны дэд сайд Б.Лосол цуглуулан яриа хийж, өнөө шөнө Монгол Улсад бугшиж байсан хувьсгалын эсэргүү Япон тагнуулчдыг баривчлана хэмээн тушаал өгч баривчлах хүмүүсийн ордериыг тараан өгчээ. Маргааш өглөө нь ДЯЯ-ны сайд Х.Чойбалсан “Японы тагнуулын хэргийг 25 хоногийн дотор байцааж дуусга. Хэрэг хүлээхгүй нэгийг нь Гэндэнгийн мэдүүлгээс иш татсан ч болно” гэж тушааснаар С.Галиндэв даргатай, Л.Б.Кичиков сургагчтай Нууц улс төрийн хэлтэс дайчлан баривчлах, мөрдөн байцаах ажлыг сургагчийн заавраар явуулжээ.

С.Галиндэвийг хэлмэгдүүлэлтийн үед хэрэгтнүүдийг байцаахдаа ширүүн хууль бусаар байцааж байсан гэж хэд хэдэн тодорхойлолтыг хожим гаргаж байсанч тодорхой баримт олдохгүй байгаа бөгөөд түүнтэй хамт ажиллаж байсан Ш.Цэнд “Галиндэв бол бичиг үсгийн чадал сайтай. Ааш зан сайхантай. ДЯЯ-ны сайн дарга нарын нэг байсан юм. Тогтуун төлөв томоотой хүн байсан” хэмээн тодорхойлжээ.

С.Галиндэвийг 1937 оны арванхоёрдугаар сарын 8-нд Засгийн газрын тогтоолоор 3 дугаар комиссар /хошууч генерал/ цолоор шагнажээ.

1938 оны долдугаар сарын 20-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын 149 дугаар тушаалаар тус улсаас ЗХУ-д явж суралцах сурагчдыг улс төрийн ба ажил хэргийн тааар хянан шалгаж шалгаруулах комиссыг Засгийн газрын дэргэд байгуулан даргад нь Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд Б.Наваан, гишүүдэд ДЯЯ-ны С.Галиндэв, МАХН-ын Төв Хорооны шинэ хүчний Жамсран

<sup>1</sup> БНМАУ-ын Их Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд. Улаанбаатар: 1956, 341

нарыг томилжээ. Гэвч С.Галиндэв уул ажлаа хийж амжилгүй албан тушаал өөрчлөгдөн өөр ажилд шилжсэн байна.

***Гурав. С.Галиндэв Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар ажилласан нь:***

1938 оны долдугаар сарын 29-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 29 дүгээр тогтоолоор С.Галиндэвийг Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар томилжээ. Тэрээр 1939 оны 3 дугаар сард Эмнэлэгийн ажилчдын зөвлөлгөөнийг зохион байгуулж, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын эрүүлийг хамгаалах явдлын байдал ба өсөлт хөгжил хийгээд цаашдын зорилгын тухай”<sup>1</sup> /Хавсралт-2/ гэсэн илтгэлийг тавьсан байна. Тус илтгэлдээ: Монгол Улсын Шинжлэх Ухааны эрүүл мэндийн салбрын байдал, үүсэл хөгжлийг дурдаад “1938 онд эмнэлгийн газруудыг байгуулах явдалд ард түмнээс ихээхэн хөрөнгийг хураалгаж тусалж байсан. ... Архангай аймагт энэ зүйлд зориулан сайн дураар хуралдуулан өгсөн төгрөг нь 200 мянган хүрсэн”-г цохон тэмдэглэжээ. Тэрээр Шинжлэх ухааны эрүүл мэндийн салбарт уламжлалт эмчилгээний арга ухаан зөрчилдөн саад болж буйг өгүүлж, эрүүл мэндийн шинэ боловсон хүчин нэн шаардлагатай байгааг салбар бүрийн орон тоо, санхүүгийн тооцоог гаргаж, “Улаанбаатар хот дахь хүн эмнэлэгийн техникумийн сургалт, мэргэжилтэн бэлтгэх нь хангалтгүй байгааг өгүүлэхдээ 1938 онд 100 орчим хүний орон тоо дутуу байхад дөнгөж 38 эмчийг бэлтгэсэн”<sup>2</sup> хэмээн илтгэлдээ өгүүлжээ.

Мөн оны гуравдугаар сарын 7-нд хуралдсан Улсын 22 дугаар Бага хурал дээр Эрүүлийг Хамгаалах Яамны сайд С.Галиндэвээс шүүмжлэхдээ: “Амар аман дээрээ эмнэлгийг өргөтгөнө гэх боловч ямар нэгэн удирдамж тусалцаа өгдөггүй. Амар хааяа нэг хөдөө хүн олон үхэж байхад та нар тусалсангүй гэх боловч тийм арга хэмжээ авч дутагдалыг зас гэдэггүй. Харин түвэд эмийн аптека яасан бэ гэдэг. Түвэд эмийг хөдөө гаргавал ардууд өөрсдөө ууж танай европ эмнэлэгт хөнгөн болно гэдэг. Хөдөөгийн эмнэлгийг мэргэжилтнийг унаатай, орон байртай болгох тухай ярихад Засгийн газраас 500 хүний барилга барих гэж байгаа түүнд орж болно гэдэг. Одоо мэргэжилтэн эмч нар хятадын муу байшинд сууцгааж байна. Танай эмч нар монголын байдлыг мэдэхгүй учраас зовж байна уу гэж асуудаг. Гэтэл эдгээр эмч мэргэжилтэн манай гуйлтаар ирсэн байхад Амар манайхыг колоничлохоор ирсэн мэт байдалтай ярьдаг”<sup>3</sup> хэмээн А.Амар сайдыг

<sup>1</sup> МУУТА. Хн-22-1-68, хдс-92

<sup>2</sup> МУУТА. Хн-22-1-68, хдс-110

<sup>3</sup> Дүйнхэржав, Г. *С.Галиндэв*. Улс төрийн хэлмэгдэгсэдийн намтрын товчоон. Улаанбаатар: 2001



шүүмжилжээ. Энэ явдал бол ЗХУ-ын төлөөлөгчийн газрын хэргийг хамаарагч Скрипко ДЯЯ-наас боловсруулсан А.Амарын тухай мэдээ материалтай танилцан түүнийг зайлуулахаар боловсруулсан хувилбарын нэгдүгээр зүйл буюу “Улсын Бага Хурлыг хуралдуулан Засгийн газар дахь А.Амарын үйл ажиллагааг тал бүрээс нь шүүмжлэх”<sup>1</sup> төлөвлөгөөнд ДЯЯ-нд ажиллаж байсан С.Галиндэвийг татан оролцуулсан хэрэг байжээ. А.Амар сайдыг зайлуулахаар төлөвлөсөн дэгийн дагуу 1939 оны 3 дугаар сарын 7-нд НТХ-ны Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдаан дээр Д.Лувсаншарав “Намын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн Амарын нам бус явдлын тухай” илтгэл тавьж, түүнийг дэмжиж 14 хүн үг хэлсэн бол<sup>2</sup>, мөн өдрийн үдээс хойш Улсын 22 дугаар Бага хурлын хуралдаан болж, Х.Чойбалсангаас “Засгийн газрын байдал ба ерөнхий сайд Амарын ажил явууллагын тухай” илтгэл тавьж, “...БНМАУ-ын дотор японы тагнуулын байгууллага 4 чиглэлээр<sup>3</sup> ажиллаж устгагдсан, бид дайсныг илрүүлэн устгаж хөрөнгөтний биш хөгжлийн замыг хангаж чадсан” гэх зэргээр тодорхойлж, түүнийг Амартай холбохын тулд Ерөнхий сайд Амарын улс төрийн шугам, итгэмж хүндийн талаар өөрийн блдлыг тоо баримт тоочин өгүүлсний эцэст “...Амарын улс төрийн шугам ажилчин ард нийтийн сонирхлоос тэс хөндлөн явж буй, ... Амар Улсын Бага Хурал, ард түмнээс итгэсэн хүндтэй их үүргийг биелүүлж чадаагүй бөгөөд ийм хүн улсын жолоог жолоодон сууж үл чадна. Амар манай хувьсгалын ажилд саад хийж байсан ба цаашид ч саад хийнэ гэхэд буруудахгүй, Би өөрийн гүйцэтгэх үүргийг гүйцэтгэлээ. Үүнийг үнэнч ард, Засгийн газрын гишүүд заавал хийж гүйцэтгэх үүрэг мөн”<sup>4</sup> гэжээ. Улмаар БНМАУ-ын ерөнхий сайд А.Амарыг 1939 оны 3 дугаар сарын 7-нд ДЯЯ-ны сайд Х.Чойбалсангийн гарын үсэг зурсан 10 дугаартай ордероор дайчлан баривчилсан билээ.

С.Галиндэв Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар ажиллах хугацаандаа 13 аймаг, Улаанбаатар, Сүхбаатар хотуудад орон нутгийн эмнэлгийг удирдах аливаа асуудлыг нь хариуцан зохицуулах эмнэлгийн хэлтсүүдийг зохих орон тоотой байгуулан ажиллуулж орон нутаг дахь эмнэлгийн ажлыг хариуцах эзэнтэй

<sup>1</sup> Хишигт, Н., Батболд, Н. “БНМАУ-ын Ерөнхий сайд А.Амар: хэлмэгдүүлэлт ба цагаатгал илтгэл.

<sup>2</sup> *Ерөнхий сайд А.Амар: үзэл бодол, үйл ажиллагаа*. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. Боть XV. Улаанбаатар: 2012, 254

<sup>3</sup> 1.Улсын ба Намын аппаратын дотор гүнзгийгээр нэвтрэн орсон Гэндэн, Дэмид нарын хувьсгалын эсэргүү байгууллага, 2.Феодалын этгээд нар ба дээд ангийн лам нарын дотор байгуулсан хувьсгалын эсэргүү байгууллага,3. Шунахай этгээдүүдийн дотор байгуулагдсан Япон, Хятадын хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллага, 4. Япон-Буриад нарын хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллага тус тус болно.

<sup>4</sup> Бат-Очир, Л. *Х.Чойбалсан (намтрын балархайг тодруулахуй)*. Улаанбаатар: 1996, 114-115

болгожээ. 1937 онд улсын хэмжээнд эмнэлгийн салбар 73 байсныг 1939 он гэхэд 117-д хүргэж 44 салбарыг шинээр байгуулж, 185 суманд хөдөөгийн хүн амд эмнэлгийн түргэн тусламж үзүүлэхийн тул асрагч нараар толгойлуулсан эмнэлгийн салбар цэгүүдийг байгуулжээ.

С.Галиндэв Эрүүл Мэндийн Яамны сайдаар ажиллах хугацаандаа 70 гаруй тушаал шийдвэр гаргажээ. Энэхүү тушаалыг шүүн үзэхэд Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааг боловсронгуй болгох, ард түмэнд эрүүл мэндийн тусламжийг цаг алдалгүй хүргэх талаар нилээд анхааран ажиллажээ. Тухайлбал: 1939 оны 1 дүгээр сарын 16-ны 4 дүгээр тушаал<sup>1</sup>/хавсралт-3/-аар үйлдвэрийн ажилчид, бусад албан хаагчдад 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн оройн цагаар үйлчлэх тухай даалгаж, оройн цагаар ажиллах эмнэлгийн тасгуудыг зааж, оройн цагаар ажиллах төсөвт 16595 төгрөгийг тусгаж байжээ.

ДЯЯ-ны ерөнхий зөвлөхийн үүрэг гүйцэтгэж байсан Л.Б.Кичиковоос 1939 оны дөрөвдүгээр сарын 4-ний өдөр ЗХУ-ын хэргийг түр хамаарагчаар ажиллаж байсан Скрипкод бичсэн илтгэх хуудсандаа “ДЯЯ-нд хэлтсийн даргаар ажиллаж байгаад одоо Эрүүлийг Хамгаалах Яамны сайдын албан тушаалд байгаа С.Галиндэвийг ажлаас нь өөрчлөхийг Чойбалсан бодож байгаа. Галиндэв тайж гаралтай. Хувьсгалын хэргээс урваж болох хүн гэж Чойбалсан надад хэлсэн”<sup>2</sup> хэмээн бичжээ.

Мөн түүний угсаа гарвалын талаар урьд нь: “Дотоодыг Хамгаалахын төлөөлөгч нөхөр Галиндэв болвоос уулаас Дөрвөдийн аймгийн ван Самданжамцын ойр төрлийн бөгөөд Сэрээ /Сойр/ туслагчийн төрсөн хөвгүүн, тайж язгууртай этгээд болно”<sup>3</sup> гэж тодорхойлж байжээ.

### ***Дөрөв. С.Галиндэвийг хэлмэгдүүлсэн нь:***

С.Галиндэвийг Эрүүл Мэндийн Яамны сайдаар ажиллаж байхад нь буюу 1939 оны 7 дугаар сарын 10-нд хувьсгалийн эсэргүү хэрэгт нэр илэрсэн хэмээн ЗХУ-ын 17 дугаар армийн тагнуулын хэлтсийнхэн баривчилжээ. /Хавсралт-4/. Тэрээр баривчлагдахаас 6 сарын өмнө ДЯЯ-нд хандан захидал хүргүүлжээ. Уг захидалдаа: “Эдүгээ үүний урд миний бие тус газраас олгосон албаны буу<sup>4</sup>-г гээгдүүлсэнг харьяат дарга сургагч нарт хэлж басхүү газраа сонинд нийтлүүлсэн боловч энэ

<sup>1</sup> МУУТА. Хн-22-1-84, хдс-4

<sup>2</sup> Дүйнхэржав, Г. *С.Галиндэв*. Улс төрийн хэлмэгдэгсэдийн намтрын товчоон. Улаанбаатар: 2001

<sup>3</sup> ТЕГ-ын тусгай архив. Сан-4, хн-1137

<sup>4</sup> 1932 оны эсэргүү хөдөлгөөнийг дарахад оролцсон гэж шагнагдсан буу.

завсар олдсонгүй бөгөөд үүнд уг буу гээгдүүлсэн төлбөрийг барагдуулсан”<sup>1</sup> хэмээжээ. Гэвч Эрүүл Мэндийн Яамны сайд дээрх хэргээс бус 1937 оны 7 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулалттай явуулсан их баривчлгааны үеэр баривчлах хүмүүсийн нэрст багтсан байжээ. Энэ баривчилгааг ДЯЯ-ны сайд Х.Чойбалсангийн гарын үсэгтэй ордер, “ажил хэргийн уулзалтаар дуудан авч ирэх”, “орон нутагт томиллолтоор явуулах” зэргээр явуулсан байдаг. Тухайлбал: “1937 оны 7 дугаар сарын 9-нд баривчилгааг хэрхэн хийсэн талаар тухайн үед ДЯЯ-ны ажилтан байсан Б.Жамбалдорж: 9-ний өдөр бүтэн сайн байсан. Би ажил шинэхэн аваад байсан болохоор ажилтайгаа танилцан албан өрөөндөө байтал утас дуугарсан. Авбал манай сайд Х.Чойбалсан байлаа. Намайг одоо хүрээд ир гэснээр яаравчлан очиж орлоо. Х.Чойбалсангийн сандлын архан хоёр хажууд нь 17 дугаар армийн бололтой энгийн хувцастай хоёр залуу зогсож байв. Маршал намайг чи үүнийг дууд, түүнийг дууд гэж баахан сайд, дарга нарыг дуудуулж тэднийг 17 дугаар армийнхан Х.Чойбалсангийн өрөөнд баривчлан цааш нь аваад явдаг байсан. Энэ хүмүүсийг баривчлахыг манай яам огт мэдээгүй юм шүү”<sup>2</sup> гэжээ.



С.Галиндэв ЗХУ-д хоригдож байх үеийн зураг

С.Галиндэвийн хувьсгалын эсэргүү хэрэгт нэр илэрсэн асуудлыг шүүн үзэхэд түүнийг баривчилсан 7 дугаар сарын 10-ны өдрөөс хойш мөн сарын 14-ний өдөр ДЯЯ-ны Хэрэг Эрхлэх Газрын дарга асан хэрэгтэн Гомбын мэдүүлгээр нэр илэрсэн хэмээгээд улаан ягаан бэхээр Галиндэв гэж бичжээ. Мөн оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Хэрлэн дэх 31 дүгээр отрядын комиссар агсан хэрэгтэн Дамдинсүрэнгийн анхдугаар мэдүүлгээр илэрсэн хэмээн цэнхэр үзгээр нэрийг нь бичжээ. Мөн 7 дугаар сарын 9-нд дайчлан баривчлах тогтоол нь гарсан Д.Лувсаншаравын мэдүүлэгт нэр дурдагжээ. С.Галиндэвийн хэргийн бүрдлийг хожим хийсэн мэт баримт материал

харуулж байна. Энэ материал нь С.Галиндэвийг хэрэгт холбогдолтой болгох гэж БНМАУ-аас хүмүүсийн мэдүүлгийг хуулбарлан ирүүлж түүний нэрийг бичиж хэрэгт холбогдох нэг баримт болгон тулгаж байсан байж болзошгүй юм. Ямартай ч С.Галиндэвийг ЗХУ-д “Дело №17093”<sup>3</sup> дугаартай Нармай монголын хувьсгалын

<sup>1</sup> ТЕГ-ын Тусгай архив. Сан-4, хх--1137

<sup>2</sup> *Харьд хэлмэгдсэн монголчууд*. 17 дугаар боть. Улаанбаатар: 2013, 138

<sup>3</sup> *Харьд хэлмэгдсэн монголчууд*. 17 дугаар боть. Улаанбаатар: 2013, 147

эсэргүү хорлон сүйтгэх бүлгийн хэрэгт А.Амар, Д.Лувсаншарав Д.Догсом нарын хамт багтаасан байжээ.

С.Галиндэвийн гэр бүлийн талаар анкетэнд нь Эхнэр Дулмаа Улаанбаатар хотын 3 дугаар хороонд суудаг. Охин Мэнд хэмээн тэмдэглэжээ. /Хавсралт-5/

С.Галиндэвийг ЗХУ-д хүргэн ЗСБНХУ-ын ДШЦК-ын 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн эрүүгийн хуулийн 58-2, 58-6, 58-11 дүгээр зүйлүүдэд зааснаар БНМАУ-ын засгийн газрыг зэвсэгт бослогын замаар устгах, Япон улсын ивээл дор капитлист засаг байгуулахыг өөрийн зорилго болгосон, Японы тагнуулын байгууллагын тусын тулд тагнуулын үйл ажиллагаа явуулсан гэгдэж дээд хэмжээгээр шийтгэж, бүх хөрөнгийн хураахаар шийдвэрлэжээ. Улмаар ЗХУ-ын ДШЦК-ын С.Галиндэвийн хэргийг хянан үзээд 1956 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн №4н-022693/56 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгажээ.

1958 оны 5 дугаар марын 12-нд Увс аймгийн Туруун сумын Соёр овогтой Түдэв төрсөн ах Галиндэвийн хэргийг хар цагаатган шүүж өгөхийг хүсэн өргөдөл гаргаснаас даруй 5 жилийн дараа С.Галиндэвийн Орос хэргийн магадлал хуулбарлагдан ирснээр БНМАУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын 1963 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 53 дугаар тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгажээ.

## **Дүгнэлт**

Дөрвөд далай хан аймгийн Дайчин вангийн хошууны сүүлчийн засаг ноён Н.Самданжамцын ураг төрлийн Сайр тайжийн хүү Галиндэв эрдэмд шамдан хичээнгүйлэн сурснаар Гаалийн түр сургуулийг хугацаанаас нь өмнө дүүргэж, Гаалийн хорооны ажлыг чадварлагаар гүйцэтгэж, ДХГ-ын дарга З.Шижээгийн хараанд өртөн тагнуулын байгууллагад ажиллаж, 1932 оны эсэргүү хөдөлгөөнийг дарах зэрэг ажлуудыг тус газрын даргын тушаал, ЗХУ-ын сургагч нарын заавраар, хараа хяналтанд хэлмэгдүүлэлтэнд оролцожээ. Түүнийг Эрүүлийг Хамгаалах яамны сайдаар томилон ерөнхий сайд А.Амарыг унагах төлөвлөгөөт ажилд татан оруулж ажиллуулжээ. Ерөнхий сайд А.Амарыг унагасны дараагаар С.Галиндэвийг хэлмэгдүүлэлтийн нэгэн гэрч болсон, “тайж язгууртай этгээд болно” хэмээн угсаа гарвалын хувьд буруутган хилс хэрэгт шийтгэжээ.

С.Галиндэв Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар богино хугацаанд ажиллахадаа томоохон зорилтот ажлуудыг гүйцэтгэж, Монголчуудын эрүүл мэндийн асуудлыг эрхэлсэн байгууллагын эх суурийг монгол орны өнцөг булан

бүрт байгуулах ажлыг гүйцэтгэж чадсан, эмнэлэгийн байгууллагуудыг шөнийн цагаар ажиллуулах анхны тушаалыг гаргаж хэрэгжүүлсэн монгол түмнээ гэсэн сэтгэлтэй зүтгэсээр харьд хэлмэгдсэн томоохон сэхээтнүүдийн нэг байжээ.

С.Галиндэвийн ДХГ,ДЯЯ-нд ажиллаж байсан үеийн хувийн хэрэг, элдэв тодорхойлолт, хилс хэрэгт хэлмэгдэхдээ өгсөн мэлүүлэг анкет зэргийг Үндэсний төв архивийн газрын баримт материалтай нэгтгэн судалж үзсэнээр алтан ургийн угсаа гарвал бүхий засаг ноёны удам угсааныхны хувь заяаны асуудал хэрхсэнг, тухайн цаг үеийн улс төр хийгээд ЗХУ-ын зүгээс баримталж байсан алтан ургийн угсааныхны талаарх бодлогыг харж болохоор байна. Тухайлбал: С.Галиндэвийг ДХГ-т ажиллаж эхэлхээс нь авахуулаад “тайж язгууртай” хэмээх тодорхойлолтыг орон нутаг хийгээд ойр төрлийн хүмүүсээр гаргуулан авч, хожим түүгээр нь хэлмэгдүүлэх ажлыг явуулжээ.

**Abstract:** S.Galindev was the son of the noble taj Sair who was the descendent of N.Samdanjamts noyan of the Daicing vang banner of Durvud dalai khan confederate. He recruited by Z.Shijee, chief of the Central Intelligence Agency of PRM and was participated to suppress the Mongolian Anti-Soviet Uprising (so called Left-wing deviationist) when he was worked in Intelligence Agency of the Minister of Interior. And Stalinist Great Purge in the 1937 was carried out by Soviet agents and involved by S.Galindev his The Secret Political Section. Then he ordained the Minister of Health Affair and also involved to impeach the Prime Minister A.Amar. He condemned A.Amar in the 22th Little Khural. Soon after S.Galindev was arrested, jailed because of his noble origin in the 1939, and then he executed in the Soviet Union.

**С П И С О К**

х и ц, учившихся в СССР, обвиняемых по делу "Заговор"

454

Ф А М И Л И Я	Какую школу окончил.
1. САМБУ	Тверская кав.школа
2. ЛУБСАН-ДОРИН	1-й курс КУТВ в 1937 году
3. МАКСОР	КУТВ
4. ГУВАШИН	1-й курс КУТВ
5. ДАШИ-ЗЫГБЕ	Тверская кав.школа и Военная Академия РККА.
6. НЕМАЛУ	Тверская кав.школа
7. ДУЦИШ	КУТВ и Военная Мед.Академия
8. БЕ. Е-ОЧИР	Тверская кав.школа
9. АЛИН	Военная Академия РККА
10. ЗАГЧЕК	Тверская кав.школа
11. ЖАМЬИНКАП	Тверск.кав.школа и Воен.Ак.РККА
12. ЧОЙНЦОЛ	Военная Академия РККА
13. ПУРБО	КУТВ
14. САМДАН	КУТВ
15. ХУДАН	Авиашкола в Оренбурге
16. МАЛЫШКИ	Тверск.кав.школа и Воен.Академия
17. ИЦАМ-СУРУН	КУТВ и курсы по переподготовке партактива в Москве.
18. ЦЕРЕН-ДАГВА	Тверская школа и 1У упр. Штаба РККА.
19. БАГЛАР	Воен.Медич.Академия в Ленинграде
20. САНДАЛ (НЭО)	КУТВ
21. ДАМДИН	Авиашкола в Оренбурге
22. ТУДУВ ДОРИН <i>хэвхэн мэдээлэлээр 20-аар дугаар</i>	КУТВ
23. ДУЛМА	КУТВ
24. ГОМБО	Военная Академия РККА
25. ГОМБЕК НАРАБ	Тверская кав.школа
26. БАТОРУН	Военная Академия РККА
27. ЛУБСАН	Военная Академия РККА
28. НАСАН-БАТО	КУТВ
29. ДЖИРМУТУ	КУТВ
30. Б. ДН-БАТОР	КУТВ
31. ХОРКО	Военная Академия РККА
32. ДАДАН	Военная Медицинская Академия
33. ХУ...	КУТВ и Горная Академия.

Тайлбар: "Заговор" хэргийн нэрсийн жагсаалт.

СССР  
Народный Комиссариат Внутренних Дел

ОРДЕР № 3266

августа 1939 г.

ан

Центральный архив ФСБ РФ

Государственной Безопасности  
на производство

ареста  
Талинды - Сайры

В приеме арестованных  
НКВД



Народный Комиссар Внутренних Дел СССР

Начальник Второго Отдела  
1-го управления НКВД СССР

*[Handwritten signature]*

35

Тайлбар: Эрүүлийг Хамгаалах Яамны сайд С.Галиндэвийг дайчлан баривчлах ордер.

**КВБД СССР**

**Анкета арестованного**

ВОПРОСЫ:	ОТВЕТЫ:
1. Фамилия	Сайри
2. Имя и отчество	Салиндэв
3. Год и место рождения	Родился в 1907 году МНР, область (край) Обсо-ног район село Хиргас гор.
4. Постоянное местожительство (адрес)	Улан-баатар
5. Профессия и специальность	
6. Последнее место службы и должность или род занятий	а) учреждение <u>Министерство Юстиции МНР</u> Предприятие б) должность <u>министр</u> в) звание <span style="border: 1px solid black; padding: 2px;">Центральный архив ФСБ РФ</span> г) в систему какого Наркомата, или другого руководящего органа входит учреждение (предприятие) д) если не работает—когда уволен „ „ 193 г.
7. Партийная принадлежность	а) в прошлом <u>член ЦКРП</u> б) в настоящее время билет №
8. Национальность	<u>Монгол.</u>
9. Гражданство (при отсутствии паспорта, указать какой документ удостоверяет гражданство)	а) гражд. (подд.) <u>МНР</u> б) паспорт № кем выдан

Тайлбар: ОХУ-аас хуулбарлан авч исэн С.Галиндэвийн 3 хуудас анкет.